

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ, БҮТЭЦ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан үндэсний төв (цаашид “Өвчний хяналт, сэргийлэлтийн төв” гэх)-ийн удирдлага, зохион байгуулалт, чиг үүргийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад энэ дүрмийн зорилго оршино.

1.2. Өвчний хяналт, сэргийлэлтийн төв (цаашид “ төв” гэх) нь Монгол Улсын хүн амын өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг тандах, судлах, хариу арга хэмжээг авах, эрүүл мэндийн мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулж, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий байгууллага байна.

1.3. Төв нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн Хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ дүрмийг мөрдлөг болгон ажиллана.

1.4. Төв нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шууд удирдлагад харьяалагдан ажиллана.

1.5. Төвийн оноосон бүтэн нэр “ Өвчний хяналт, сэргийлэлтийн төв”, товчилсон нэр нь “ӨХСТ”.

1.6. Төвийн нэрийг англи хэлээр “ Center for Disease Control and Prevention” гэж орчуулж үйл ажиллагаандаа хэрэглэнэ.

1.7. Төв нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, бэлгэдэл, санхүүгийн харилцах данстай байна.

1.8. Төв нь байгууллагын дотоод журамтай байна.

Хоёр. Төвийн үндсэн чиг үүрэг

2.1. Төв нь Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 12.1-т заасан чиг үүргийг тус хуулийн 5.1-т заасан тусламж, үйлчилгээний төрлийн хүрээнд хэрэгжүүлэхээс гадна дараах чиг үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- 2.1.1. нийгмийн эрүүл мэндийн талаар баримтлах хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөнд тусгах санал боловсруулж эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;
- 2.1.2. нийгмийн эрүүл мэндийн орон тооны бус үндэсний зөвлөлөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах;
- 2.1.3. нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
- 2.1.4. халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг тандан судлах, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;
- 2.1.5. ОУЭМД-ийн үндэсний зохицуулагчийн чиг үүргийг гүйцэтгэх;
 - 2.1.5.1. тайван цагт нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд хүргэж болох эрсдэлийг тандан судлах, эрт илрүүлэх, бэлэн байдлын төлөвлөлт хийх, төлөвлөлтөд тогтмол давтамжтай тодотгол хийх;
 - 2.1.5.2. нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед Тохиолдлын удирдлагын тогтолцоог идэвхжүүлэн хариу арга хэмжээг тухай бүр төлөвлөн хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
 - 2.1.5.3. холбогдох байгууллагыг оролцуулан эрсдэлийн үнэлгээ хийж, үнэлгээний дүнд үндэслэн зөвлөмж боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллах;
 - 2.1.5.4. нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед Эрсдэлийн үеийн харилцаа холбоог хэрэгжүүлж нөхцөл байдлын бодит хугацааны мэдээ, мэдээллээр бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарыг тогтмол хангах, иргэдэд мэдээ, мэдээлэл түгээх;
 - 2.1.5.5. нийгмийн эрүүл мэндийн эрсдэлийг хянах, тодорхойлох зорилгоор салбар дундын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх,
 - 2.1.5.6. нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тохиолдолд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж иргэдийг татан оролцуулах, дайчлах;
 - 2.1.5.7. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хүний нөөцийн зохистой хуваарилалт, зохицуулалт хийх чиглэлээр зөвлөмж боловсруулах, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх;
 - 2.1.5.8. гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ашиглах эрүүл мэндийн салбарын эм, эмнэлгийн хэрэгсэл, тэдгээрийн түүхий эд, эмнэлгийн тоног төхөөрөмж, ариутгал

халдваргүйтгэлийн бодис, урвалж, оношлуурын нөөц бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, түгээх;

- 2.1.6. хил, боомтын нэвтрэх цэгт эрүүл мэндийн хяналтын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, бодит цагийн горимоор мэдээлэл солилцох, хянах, хариу арга хэмжээг төлөвлөх;
- 2.1.7. зоонозын халдварт өвчин болон байгалийн голомтын тархалт цар хүрээ, идэвхжил, эрсдэлийн түвшинг тогтоох эрт сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх, хяналтанд авах арга хэмжээг улсын хэмжээнд төлөвлөн хэрэгжүүлэх;
- 2.1.8. зоонозын халдварт өвчний үүсгэгчийн өсгөвөр, омог, эерэг сорьцыг баталгаажуулах, амьд омгийн сан бүрдүүлэх, онош зүйн лавлагаа тусламж, үйлчилгээг олон улсын шаардлагад нийцсэн дэвшилтэт технологийг ашиглан үзүүлэх;
- 2.1.9. дархлаажуулалтын үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах;
- 2.1.10. улсын хэмжээнд халдварт өвчний ариутгал, халдваргүйжүүлэлт, мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангах;
- 2.1.11. хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- 2.1.12. хүн амын эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжихэд чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох, эрсдэлт зан үйлийг бууруулах арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, эрүүл мэндийн нөлөөллийн үйл ажиллагааны хэрэгжилтийг зохицуулах;
- 2.1.13. хүн амын эрүүл мэндэд эрсдэл учруулах бүхий хүрээлэн буй орчны эрсдэлт хүчин зүйлээс хамгаалах арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
- 2.1.14. хими, цацрагийн аюулгүй байдлыг тандах, шаардлагатай хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, энэ чиглэлээр хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулах;
- 2.1.15. нийгмийн эрүүл мэндийн нэгдсэн лавлагаа лабораторийн чадавхыг бэхжүүлэх, био-аюулгүй байдал, био-аюулгүй ажиллагааг чиглэлээр бусад лабораторийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;
- 2.1.16. эрдэм шинжилгээ судалгааны тэргүүлэх чиглэл боловсруулж, судалгааг зохион байгуулах, судалгааны үр дүнг нийтэд мэдээлэх, тайлагнах;

- 2.1.17. нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр био-технологи, инновацийг хөгжүүлэх, биобэлдмэл үйлдвэрлэх, ханган нийлүүлэх;
- 2.1.18. нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшүүлэх болон урт, богино хугацааны сургалт зохион байгуулах;
- 2.1.19. нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр статситик мэдээ, мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, үндсэн үзүүлэлтүүдийг тооцох, эмхэтгэн түгээх, мэдээлэх;
- 2.1.20. бусад холбогдох хууль тогтоомжоор заасан чиг үүргийг гүйцэтгэнэ.

Гурав. Төвийн удирдлага

- 3.1. Төвийн захирлыг (Цаашид “ Ерөнхий захирал” гэх) эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.
- 3.2. Ерөнхий захирал нь эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өмнө хариуцлага хүлээнэ.
- 3.3. Төвийн дэд захирлыг Ерөнхий захирал томилж, чөлөөлнө.
- 3.4. Ерөнхий захирал нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
 - 3.4.1. хууль, тогтоомж, Засгийн газар, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, явц, биелэлтэд хяналт тавих;
 - 3.4.2. батлагдсан төсвийн хүрээнд баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан төвийн орон тоо, цалингийн санг тогтоох;
 - 3.4.3. хамаарах чиг үүргийн хүрээнд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд нотолгоонд суурилсан мэдээллээр хангах;
 - 3.4.4. байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөх дотоод журам болон холбогдох эрх зүйн баримт бичгийг баталж мөрдүүлэх;
 - 3.4.5. өөрийн эрх хэмжээний хүрээнд гэрээ хийх, төвийг үндэсний түвшинд болон гадаад улсад төлөөлөх;
 - 3.4.6. ерөнхий захирлын эрх хэмжээнд хамаарах асуудлаар тушаал гаргаж, холбогдох дүрэм, журам, заавар, хуваарь батлах, биелэлтийг нь зохион байгуулж, үр дүнг тооцох;
 - 3.4.7. хууль тогтоомжид заасан бусад эрх.
- 3.5. Ерөнхий захирал нь өмчийн хэлбэрээс үл хамаарч аливаа хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд удирдах ажил хавсран гүйцэтгэхийг хориглоно.

3.6. Ерөнхий захирал нь байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг холбогдох удирдах дээд байгууллагын өмнө хариуцна.

3.7. Ерөнхий захирал тухайн жилийн байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бусад холбогдох газарт тогтоосон хугацаанд хүргүүлнэ. Үүнд:

- 3.7.1. байгууллагын тухай жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт;
- 3.7.2. төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт;
- 3.7.3. ниймийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, тоо хэмжээ, санхүүжилтийн хэмжээг холбогдох тушаал, шийдвэрийн дагуу нэгтгэсэн тайлан;
- 3.7.4. ниймийн эрүүл мэндийн тэргүүлэх чиглэлийн дагуу улсын төсөв, Эрүүл мэндийг дэмжих сан, хандив, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт;
- 3.7.5. мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт;
- 3.7.6. хэрэглэгчийн үнэлгээ.

Дөрөв. Төвийн санхүүжилт, санхүүгийн Тайлан тэнцэл, бүртгэл

4.1. Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- 4.1.1. улсын төсвийн санхүүжилт;
- 4.1.2. эрүүл мэндийн даатгалын сан;
- 4.1.3. эрүүл мэндийн дэмжих сан;
- 4.1.4. олон улсын төсөл хөтөлбөр, хандив, тусламж, дэмжлэг;
- 4.1.5. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

4.2. Төвийн санхүүгийн жил тухай оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, мөн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

4.3. Төв нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр санхүүгийн тайлан боловсруулж аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

4.4. Эд хөрөнгийн дотоодын тооллогыг хууль тогтоомжид заасан хугацаад нь явуулж, жилийн тайлан тэнцэлд тусгана.

4.5. Төсвийн тухай хуульд заасны дагуу өөрийн чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, урсгал зардлын төлөвлөгөөг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнээр батлуулна.

Тав. Төвийн эд хөрөнгийн захиран зарцуулахтай холбоотой эрх, үүрэг

5.1. Төв нь эд хөрөнгийн талаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

Зургаа. Бусад

6.1. Энэ дүрэмд зааснаас бусад асуудлыг Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

6.2. Дүрэм нь төвийг улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

---oOo--

Өвчний хяналт, сэргийлэлтийн төвийн бүтцийн зураглал

